



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/63

Цагаан-Уул сум

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 онд Орон нутгийн Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Малчдын эрүүл мэндийг дэмжих ажлын хүрээнд Малчдад зориулсан сургалт сурталчилгааны ажлын техникийн тодорхойлолт боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ахлагч: У.Аварзэд (Засаг даргын орлогч)


Гишүүд: М.Оюунчимэг (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: М.Дуламжав (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

2. Ажлын даалгавар боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, захиалагчид танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (У.Аварзэд)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр)-т даалгасугай.

ДАРГА



С.ТОНЧИГНЯМ